



ХҮҮХДИЙН УРЛАН БҮТЭЭХ ТӨВИЙН 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

1.2 ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

Шийдвэрийн дэс дугаар	Зүйл, заалтын дэс дугаар	Шийдвэрийн нэр, огноо, дугаар, агуулга	Хэрэгжилтийн явц	Үнэлгээ	Шалтгаан
1	2	3	4	5	6
			Салбар чиглэл: 1		
1.а. Монгол Улсын хууль					
	9, 27.1, 31	Төрийн албаны тухай хууль	Төрийн албаны зарчмыг баримтлан хууль тогтоомжид заасны дагуу үйл ажиллагаагаа явуулж байна.	100	-
	16.5	Төсвийн тухай хууль		100	-
	6, 7	Шилэн дансны тухай хууль	Хуулиар тогтоосон хугацаанд https://shilendans.gov.mn/orq/4315 сайтад мэдээллийг тогтмол байршуулж байна.	100	-
	5	Хөдөлмөрийн тухай хууль	Хууль тогтоомжид нийцүүлэн хөдөлмөрийн дотоод журмыг батлан мөрдүүлж, ажилтныг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагад тохирсон нөхцөлөөр ханган ажиллаж байна.	100	-
	6	Хүүхэд хамгааллын тухай хууль	Хуульд заасны дагуу “Хүүхэд хамгааллын төлөвлөгөө” гарган мөрдөж ажиллаж байна.	100	-
	7, 8, 9	Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль	http://huuhdiinurlan.ub.gov.mn/ сайт, “Монголын Хүүхдийн Урлан Бүтээх төв” Фэйсбүүк пейж болон мэдээллийн самбарт тогтмол мэдээллүүдийг шинэчлэн байршуулж, үйл ажиллагаа, хүний нөөц, төсөв санхүүгийн ил тод байдлыг ханган ажиллаж байна.	100	-
	7, 12, 13, 14, 15, 16	Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль	Байгууллагад ирсэн өргөдөл, гомдлыг хуульд заасны дагуу хугацаанд нь шийдвэрлэж байна.	100	

1.б. Улсын их хурлын тогтоол					
1	2	3	4	5	6
		Улсын Их Хурлын 2024 оны 64 дүгээр тогтоол. 03/6012 тоот албан бичиг	Төвийн захирал Монгол Улсын бүсчилсэн хөгжил чуулганд оролцсон.	100	
		03/6721, Улсын Их Хурлын 2023 оны 59 дүгээр тогтоол	Байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээ, эрхлэх асуудлын хүрээнд хамаарах арга хэмжээг тусгаж хэрэгжүүлнэ.	100	
1.г. Ерөнхийлөгчийн зарлиг					
		МУ-ын ерөнхийлөгчийн 2021 оны 63-р зарлиг “Тэр бум” мод тарих аянд нэгдэх	Айцын даваанд тарьсан мод услах, арчлах ажлыг хуваарийн дагуу гүйцэтгэж төвийн 28 албан хаагч оролцож ажиллалаа.	100	-
1.е. Засгийн газрын тогтоол					
		Засгийн газрын тогтоол 03/5807 “Хүний нөөцийн ажилтны өдрийн чуулганд оролцох тухай		100	-
		05-05/6780, Засгийн газрын 2013 оны 169-р тогтоол	. Нийслэлийн засаг даргын тамгын газрын урилгаар энэ жил "Олон улсын сурагч солилцоо, Оросын Урлагийн академийн гишүүн Михаил Горшунов, В.И. Суриковын нэрэмжит Уран зургийн академ, “Монгол-Японы соёлын фестиваль-2024” арга хэмжээг, Их эзэн Чингис хааны мэндэлсэн өдөр “Монгол бахархлын өдөр зэрэг томоохон арга хэмжээг зохион байгуулж ажилласан. Олон Улсын 8 орны 70 гаруй сурагч, багш, уран бүтээлчид	100-	-

			оролцсон.		
	2,6 12,6	МУЗГ-ын 2024 оны 109 дүгээр тогтоо. 01/6176	Нийслэлийн Засаг Даргын 2024 оны 11 сарын 01-ний өдрийн 01/6176 тоот албан бичигт тусгасан 109 дүгээр тогтоолыг дотоод журамдаа нийцүүлэн шинэчлэн батлуулж мөрдөж ажиллана.	100	-
		05-06/6882, МУЗГ-ын 2020 оны 206 дугаар тогтоол “Бодлогын баримт бичиг”	Тайланг хүргүүлж ажилласан.	100	-
1.ж. Нийслэлийн засаг даргын захирамж болон албан даалгавар					
		03/5034,НЗД-ын А/274 дүгээр захирамж	Зөвлөмжийг хүлээн авав.	100	-
		НЗД-ын 03/5434 03 албан даалгавар Санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлж, санхүүгийн сахилга хариуцлагыг баримтлан ажиллах тухай	НЗДТГазраас ирүүлсэн албан даалгаварын хэрэгжилтийг 2025 оны 01-р сарын 10- ны өдрийн дотор Нийслэлийн дотоод аудитын албанд хүргүүлэхээр ажиллаж байна.	100	
		03/5087, НЗД-ын А/1048 захирамж	2024 оны 09 дүгээр сарын 21-ний өдөр Нийслэлийн Засаг Даргын 2024 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн А/1048 дугаар захирамжийн дагуу “Автомашингүй өдөр-2024” арга хэмжээнд Хүүхдийн урлан бүтээх төв Нийслэлийн төв талбайд байгууллага сурталчлан, суралцагч хүүхдүүдийн уран бүтээлээр үзэсгэлэн гаргаж, FACEART зохион байгуулж ажиллав.	100	-
		03/7094, НЗД-ын А/352 дугаар захирамж	Авлигын эсрэг үйл ажиллагааны 2024 оны төлөвлөгөөний биелэлтийг хүргүүлсэн болно.	100	
		НЗД-ын 03/263 тоот тогтоол хүргүүлэх тухай	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр шууд болон харьцуулалтын аргаар хийж болох мэдээлэлтэй танилцсан.	100	-
		НЗД-ын 03/132 захирамж	Хэрэгжилтийг ханган ажилласан.		-
		НЗД-ын 01/384 тоот албан даалгавар	Төлөвлөгөөнд тусгах саналыг боловсруулан илгээж ажилласан	100	-

		НЗД-ын 03/464 тоот захирамж	Нийслэлийн Засаг Даргын А/91 дүгээр захирамжийн дагуу Иргэдийн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн биелэлтийн мэдээ тайланг улирал тутам гаргаж хүргүүлж байна.	100	-
		НЗД-ын 03/5087 тоот захирамж	2024 оны 09 дүгээр сарын 21-ний өдөр Нийслэлийн Засаг Даргын 2024 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн А/1048 дугаар захирамжийн дагуу “Автомашингүй өдөр-2024” арга хэмжээнд Хүүхдийн урлан бүтээх төв Нийслэлийн төв талбайд байгууллагаа сурталчлан, суралцагч хүүхдүүдийн уран бүтээлээр үзэсгэлэн гаргаж, FACEART зохион байгуулж ажиллав.	100	-
		НЗД-ын А/630 дугаар захирамж	Нийслэлийн Засаг Даргын 2024 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн А/630 дугаар захирамжийн хэрэгжилтийг ханган ажилласан.	100	-
		НЗД-ын 03/5434 тоот албан даалгавар	Албан даалгаварын хэрэгжилтийг 2025 оны 01-р сарын 10 ны өдрийн дотор Нийслэлийн дотоод аудитын албанд хүргүүлэхээр ажиллаж байна.	100	
1.и. Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол					
119					-
Нийслэлийн Онцгой Комиссоос гаргасан шийдвэрийн биелэлт					
1					

НЭГ. ХУУЛИАР ТУСГАЙЛАН ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:

1.1 Хүүхдийн хүсэл сонирхолд нийцүүлэн авьяасыг нь хөгжүүлж, мэргэжлийн чиг баримжаатай болгож, тодорхой түвшний мэдлэг, ур чадварыг эзэмшүүлнэ

- 2024-2025 оны хичээлийн жилд тус төв нь 18 төрлийн 23 дугуйланд 2100 хүүхэд элсэн суралцав.

“ӨВ СОЁЛОО ДЭЭДЭЛДЭГ БҮТЭЭЛЧ МОНГОЛ ХҮҮХДИЙН ТӨЛӨӨ” уриан дор олон улс болон улс нийслэлийн хүрээнд үндэсний бичиг соёл, өв уламжлалыг хүүхэд багачуудад сурталчлан таниулах олон талт ажлуудыг зохион байгуулав.

- Уран бичлэгийн дугуйланд суралцагч 53 дугаар сургуулийн сурагч Б.Батцэцэг сурагч Э.Учрал “Ээждээ”, М.Номин-Эрдэнэ, А.Нарангоо нар “ГОО НОМИН” бие даасан үзэсгэлэнг Нийслэлийн ерөнхий боловсролын 97 дугаар сургууль дээр гаргав.

- Үндэсний бичиг үсгийн баярыг тохиолдуулан Нийслэлийн Ерөнхий боловсролын 5, 103 дугаар сургуулийн хүүхэд багачуудад Монгол Уран бичлэгийн сургалтуудыг зохион байгуулж ажиллалаа.

- Хэл Иргэншлийн Эрдмийн Хүрээлэнгээс зохион байгуулагддаг “Хичээнгүй бичиг”, Монгол туургатны “Миний монгол бичиг” олон улсын уралдаан, “Төрөлх Монгол хэл” уран бичлэгийн улсын IX уралдаан зэрэг үзэсгэлэн уралдаануудад хүүхэд багачуудаа амжилттай оролцуулж ажиллав.



- Г.Болормаа багштай Монгол уран бичлэгийн хулсан үзгийн ангийн сурагч Батцэцэг, Энхтуяа нарийн хамтарсан “Монгол бичиг бидний бахархал” сэдэвт бие даасан үзэсгэлэнг 2024 оны 03 дугаар сарын 01-ний өдөр Нийслэлийн ерөнхий боловсролын 53 дугаар сургуулийн урлаг заалд гаргаж, Баянзүрх дүүргийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын хэлтэстэй хамтран ажиллав.

- Г.Болормаа багштай Монгол уран бичлэгийн хулсан үзгийн ангийн сурагч Батцэцэг, Энхтуяа нарийн хамтарсан “Монгол бичиг бидний бахархал” сэдэвт бие даасан үзэсгэлэнг 2024 оны 03 дугаар сарын 06-ны өдөр Нийслэлийн ерөнхий боловсролын 24 дүгээр сургуулийн урлаг заалд гаргаж, Чингэлтэй дүүргийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын хэлтэстэй хамтран ажиллав.



2024-2025 оны стандарт сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу Монгол уран бичлэгийн ангийн дугуйлангийн сурагчдад монгол бичгийн хичээлийн мэдлэгийг нэмэгдүүлэн унших, бичих чадварыг хөгжүүлэх, дадлага хичээлээр дамжуулан үзүүлэн таниулах материал, ном сурах бичиг ашиглан хөтөлбөрийн дагуу анхан,

дунд, гүнзгий шатны мэдлэг олгож, сурагчдын чадварыг дээшлүүлэх зорилгоор үзэсгэлэн уралдаанд хамрууллаа. Үүнд:



Гандантэгчилэн хийдээс жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг Монгол туургатны “Миний монгол бичиг” олон улсын уралдаанд дугуйлангийн сурагч Г.Намуунцэцэг, У.Байгаль, Г.Номинтуяа, Н.Хүслэн, Э.Уяхан нар бүтээлээрээ болон бичгийн уралдаанд оролцсон. Н.Хүслэн шагналт байрт орлоо.



Уран бичлэгийн дугуйланд 3 дахь жилдээ амжилттай суралцсан 97-р сургуулийн 12 дугаар ангийн сурагч А.Нарангоо, М.Номин-Эрдэнэ нар хамтарсан үзэсгэлэнгээ амжилттай гаргаж сургуулийн шилдэг төгсөгч, Монголын сурагчдын холбооны Тэргүүний сурагч медалиар шагнуулав.



Монголын Хүүхдийн Ордноос зохион байгуулдаг “Хичээнгүй бичигтэн 2024” Улсын уралдаанд дугуйлангийн сурагчид бүтээлээрээ оролцсон. Нийт 9 сурагч оролцсоноос Спортын төв сургуулийн 9 дүгээр ангийн сурагч Ц.Нандин дунд насны ангилалд Тэргүүн байр эзэлсэн.



1.2 Төвийн сургалтын үйл ажиллагааг мэргэжлийн багш удирдан зохион байгуулна

-Багш, албан хаагчдад Монгол бичгийн анхан шатны сургалтыг баасан гараг бүр тогтмол хичээллүүлж хэвшүүлэв. Багшийн хөгжил, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлж, сургалтын чанарыг сайжруулан, цахим сургалтыг төрөлжүүлэн бүрээр зохион байгуулав.



-Багш нарын ур чадварыг дээшлүүлэх зорилтын хүрээнд уран зургийн багш нар уран баримлын бие даасан дадлага, уран хайчилбарын сургалтад хамрагдав.



-2024 оны 09 дүгээр сарын 05-ны өдөр Хүүхдийн Урлан Бүтээх төв нь Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам, Монгол Улсын Соёл Урлагийн их сургууль, МГАХИ СУРИКОВА-тай хамтран төвийн “Орд” арт галерейд “График болон Уран зураг”-ийн мастер класс сургалтыг зохион байгууллаа. Тус арга

хэмжээнд Оросын урлагийн академийн гишүүн Михаил Горшунов болон В.И. Суриковын нэрэмжит уран зургийн академийн багш Лилия Устюгова нар хүрэлцэн ирж, мастер класс сургалтыг хийж, Хүүхдийн урлан бүтээх төвийн 22 багш мөн Соёл урлагийн их сургуулийн Дүрслэх урлагийн ангийн 20 оюутан хамрагдав.



1.3 Ерөнхий боловсролын сургуулийн анги удирдсан болон мэргэжлийн багш нар, эцэг эх асран хамгаалагчидтай хамтран ажиллаж тэдэнд мэргэжлийн зөвлөгөө өгч, дэмжлэг үзүүлнэ”

-Төвийн “Эко урлал”-ын дугуйлангийн багш Б.Нарантунгалаг 2024 оны 03 дугаар сарын 24-ний өдөр “Орд арт” галерейд “Нам гүм дунд” бие даасан үзэсгэлэн гаргав. Уран бүтээлч нь үзэсгэлэнгээрээ олсон утас болон кофег ашиглан байгальд ээлтэй уран бүтээлийг хийж, өсвөр үеийнхний авьяас чадвар, бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх, урын санг баяжуулах, хэрхэн хөдөлмөрч байхыг сурталчлан таниуллаа. Энэхүү үзэсгэлэнд нийт 60 гаруй бүтээл дэлгэгдэв.



-Хүүхдийн Урлан Бүтээх төвийн захирал Д.Уранбилэгийн санаачилгаар

дүрслэх урлаг, гар урлалыг хүүхэд багачууд, эцэг эхчүүд, асран хамгаалагчдад сурталчлан таниулах, ойлголт өгөх зорилгоор “Хамтдаа урлая” контент төсөл хэрэгжүүлж, зочноор МУГЖ Д.Баттөмөр охины хамтаар 2024 оны 03 дугаар сарын 07-ны өдөр оролцов.



-Монголын зохион бүтээгчдийн нэгдсэн холбоо, Хүүхдийн урлан бүтээх төв, Боловсролын яамтай хамтран "Өсвөрийн зохион бүтээгч - 2024" үзэсгэлэн уралдааныг 2024 оны 12 дугаар сарын 13-ны өдөр Хүүхдийн урлан бүтээх төвийн Орд арт галерейд зохион байгууллаа. Тус ажиллагаанд Нийслэлийн 9 дүүрэг, 21 аймгийн багш нартай хамтран туршлага солилцон зохион бүтээгч хүүхдүүдийг чиглүүлэн ажиллав.



- Төвийн номын санг эцэг эх, асран хамгаалагчдад зөвлөгөө өгөх, хүүхдийн хөгжлийг дэмжих ээлтэй орчин бүрдүүлж “Хамтдаа урлая” гэр бүл хөгжлийн өрөө болгох чиглэлийн дагуу Тохижилтын ажлын төсөл боловсруулж, номын санд хүүхэд хөгжлийн чиглэлээр номын баяжмал хийж, зөвлөгөө өгөн ажиллаж байна.

- Жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг эцэг эх, хүүхдийн хамтарсан “ХАМТДАА ХӨГЖЬЕ” нээлттэй хаалганы өдөрлөгийг “ЖАРГАЛТАЙ ГЭР БҮЛ” сэдвээр зохион байгуулав. Тус өдөрлөг нь мэргэжлийн уран бүтээлч багш нарын дэмжлэгтэйгээр бүтээл туурвин, эцэг эх, асран хамгаалагч, хүүхэд хоорондын эерэг харилцааг нэмэгдүүлэх, дүрслэх урлагийн онцлог шинж чанар, Хүүхдийн Урлан бүтээх төвийн сургалтын ач холбогдлыг сурталчлан таниулах зорилготой.

Тус арга хэмжээ нь Эцэг эх, асран хамгаалагч, хүүхдүүдийн хамтарсан бүтээл туурвих, уралдаан зохион байгуулах, Мэргэжлийн уран бүтээлчид уран зураг, уран бичлэг, уран сийлбэрийн үзүүлбэр, бүтээл туурвих бодит дадлага хийх, Хүүхдийн урлан бүтээх төвийн үйл ажиллагаа, дүрслэх урлагийн онцлог шинж түүний ач холбогдлын талаарх мэдээ мэдээлэл хүргэх гэсэн үндсэн чиглэлийн дагуу явагдав.

Үр дүн:

Эцэг эх, асран хамгаалагч, хүүхдүүд нэг өдрийг хамтдаа цагийг үр бүтээлтэй өнгөрүүлэх, хоорондын эерэг харилцааг нэмэгдүүлэх. Хүүхдийн урлан бүтээх төвийн өнөөгийн нөхцөл байдал, үйл ажиллагаатай танилцах, дүрслэх урлагийн онцлог шинж чанар, ач холбогдлын талаар мэдээ мэдээллийг хүргэж ажилласан.





- ҮНДЭСНИЙ БИЧИГ ҮСГИЙН БАЯР"-ыг тохиолдуулан Горькийн нэрэмжит 01 дүгээр номын сантай хамтран Нийслэлийн ерөнхий боловсролын 103 дугаар сургууль, Нийслэлийн ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн сурагчдад төвийн Монгол уран бичлэгийн ангийн багш Г.Болормаа, Д.Дуламсүрэн нар Монгол уран бичлэгийн тухай ойлголт, дадлага сургалтыг хүргэв.





1.4 Сургалт явуулах орчин бүрдсэн, сургалтын хэрэглэгдэхүүн бүрэн анги танхимд сургалт явуулна

Байгууллагынхаа гадна болон дотор орчинд хяналтын үнэлгээ хийж дотор орчинд хүүхдийг болзошгүй аюул ослоос хамгаалах, урьдчилан сэргийлэхийн тулд бүх давхрууд, анги танхимд галын дохиолол, камер, гэрэлтүүлгийг нэмж байршуулан ажиллав.

Өвлийн бэлтгэл ажлын хүрээнд хийгдэх засваруудыг 4 дүгээр сараас эхлэн төлөвлөж халаалт зогсмогц 05 сараас 08 дугаар сар хүртэл аж ахуйн 4 ажилтан, няравын хамт 2 дугаар давхрын ёслолын зааланд 150 кв талбайн шаланд лак, 22-р давхрын зүүн коридорын 188,5 кв шалны талбайд лак, засварын ажил, 1 дүгээр давхрын коридорын шалны эвдэрхий хэсгийг нөхөж засварын ажил хийсэн.

Өвлийн бэлтгэл засвар ажлын хүрээнд халаалтын буусан усаар бохирын шугамуудыг буулгаж цэвэршүүлсэн. Дээвэр дээрх халаалтын босоо стекны өгөх 14 ширхэг хаалтуудыг шинэчлэн тавьсан. Бохирын худгуудыг цэвэрлэсэн. Дулааны шахах насосын удирдлагын самбарын пускателийг сольсон.

Тохижилтын ажлын хүрээнд байгууллагын орчин тойрны ногоон байгууламж, мод бутаа тэгшилж тайруулсан. Нийтийн эзэмшлийн талбайн халцарсан зүлэгтэй хэсэг дээр согооврын үр цацаж нөхөн зүлэгжүүлсэн. Мөн нөөц бололцоогоо ашиглаж, сандалтай цэцгийн савууд хийж цэцэгжүүлсэн. 07 дугаар сард байгууллагын гадна талын 4 багана, урд хэсгийг өнгөлж шавардаж эмульсээр өнгө үзэмжийг нь сэргээсэн. 08, 09 дүгээр сард зарим ангиудын хаалганы өнгө үзэмжийг сайжруулах, шалнуудыг будах лакдах зэрэг ажлуудыг хийсэн.

2024-2025 оны хичээлийн жилд үйл ажиллагаагаа эхлүүлж байгаа “Art cube” клуб нь Монгол Уран зургийн ангийн багш Н.Мөнхтуул, Үндэсний уламжлалт уран хатгамлын ангийн багш С.Ганцэцэг, Уран баримлын ангийн багш Т.Даваасамбуу, Уран зургийн анхан шатны ангийн багш Д.Энхбаяр, Шүрэн урлал, бэлэг дурсгалын ангийн багш С.Оюунсайхан, Уран баримлын анхан шатны ангийн багш Б.Ичинхорлоо бүрэлдэхүүнтэйгээр Хүүхдийн Урлан Бүтээх төвийн сурагчдад Дэлхийн сонгодог урлангийн гоо зүйн хичээлүүдийг өнөөгийн цаг үеийн дүрслэх урлагийн онцлогтой уялдуулан цуврал сургалтуудыг хүүхдүүддээ хүргэлээ.

2024 оны 11 дүгээр сарын 11-ний өдрөөс 2024 оны 11 дүгээр сарын 12-ны өдрүүдэд хүүхэд багачуудад дүрслэх урлагийн боловсролыг олгох сонирхолтой видео контент үзүүлэн чөлөөт ярилцлага өрнүүлж, гоо зүйн мэдлэгийг дээшлүүлэх. Урлагийн бүтээлээс суралцаж түүнийг хэрхэн урлагаас хэрэглээ рүү буюу өөрийн эдлэл хэрэгсэлд өнгөлөг, шинэлэг, эрч хүчийг тусгах, санаа сэдлийг төлөвшүүлэхийг

хүүхэд багачуудад сургах нь олон талын ач холбогдолтой “ART AND SOCKS” нээлттэй өдөрлөгийг “БУСДААС ТОДООР УРЛАГТАЙ СЭТГЭЭ” сэдвээр зохион байгуулж нийт Хүүхдийн Урлан Бүтээх төвийн 300 сурагчийг хамруулж ажиллав.



Мөн “ART CUBE” клуб нь “HAPPY ART AND CUPS” нээлттэй хичээлийн өдөрлөгийг 2024 оны 12 дугаар сарын 11-ний өдрөөс 2024 оны 12 дугаар сарын 12-ны өдрүүдэд зохион байгуулан ажиллав. Тус өдөрлөг нь дэлхийн алдарт зураач Ромеро Бриттогийн "HAPPY ART" урлагийн төрлөөр сурагч багачуудад аз жаргалыг мэдрүүлэм хурц тод өнгө, чөлөөт зохиомж бүхий шинэ, содон бүтээл туурвих арга зүйг олгоход оршино.





1.5 Ерөнхий боловсролын сургуулийн анги удирдсан болон мэргэжлийн баш нар, эцэг эх асран хамгаалагчидтай хамтран ажиллаж тэдэнд мэргэжлийн зөвлөгөө өгч, дэмжлэг үзүүлнэ.

Ерөнхий боловсролын сургуулиудын дүрслэх урлаг, техник технологийн багш нартай хамтран ажиллах, туршлага солилцох тэмцээн уралдаан, үзэсгэлэн, өдөрлөг, сургалт зохион байгуулав.

- Сэлэнгэ аймгийн Ерөө сумын Ерөнхий боловсролын сургууль, Сүхбаатар сумын Ерөнхий боловсролын сургуулийн багш сурагчид төвийн үйл ажиллагаатай танилцаж харилцан туршлага солилцож сургалт зохион байгуулав.



- Сэлэнгэ аймгийн Шаамар сум, Сүхбаатар сумын Технологийн багш сурагчид төвийн үйл ажиллагаатай танилцаж, туршлага солилцон сургалт зохион байгуулж, хамтран ажиллах санал хэрэгжүүлэхээр тохиров.



- Дорноговь аймгийн Эрдэнэ сумын Ерөнхий боловсролын сургуулийн 7-р ангийн сурагчид Хүүхдийн Урлан Бүтээх төвийн үйл ажиллагаатай танилцаж, 18 төрлийн 21 дугуйлангийн анги танхимуудаар зочлов.



- Арт аялал арга хэмжээний хүрээнд Хүүхдийн урлан бүтээх төв, Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газартай хамтран Өсвөрийн парламентын манлайлагч сурагчдыг тус арга хэмжээнд хамруулан Уран зураг, Монгол Уран бичлэгийн нэг өдрийн сургалтыг явуулав.



- Нийслэлийн Засаг Даргын Тамгын газар, Нийслэлийн Соёл Урлагийн газар, Нийслэлийн Боловсролын газраас зохион байгуулж байгаа хүүхэд, өсвөр үеийнхэнд зориулсан "Ирээдүйн хотын иргэн" төслийн хүрээнд Нийслэлийн Ерөнхий боловсролын 74 дүгээр сургуулийн 80 гаруй сурагч 2024 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр Хүүхдийн Урлан Бүтээх төвийн үйл ажиллагаатай танилцан нэг өдрийн дадлага хичээлд хамрагдав. Тус үйл ажиллагаанд Уран зургийн анхан шатны ангийн багш

Д.Энхбаяр, Б.Нарангэрэл нар уран зургийн Мастер класс үзүүлбэр, Хувцас загварын ангийн багш Д.Баярцэцэг хувцасны хялбарчилсан эсгүүр хийх аргачлал дадлага ажил, Уран хатгамлын багш С.Ганцэцэг, Эко гар урлалын багш Б.Нарантунгалаг, Нийгмийн ажилтан Б.Ариунбат нар байгууллагын үйл ажиллагаа танилцуулах, дүрслэх урлагийн талаарх мэдлэг ойлголтыг олгох танилцуулга лекц хичээлийг орон Монгол уран зургийн багш Н.Мөнхтуул “Art Cube” арга хэмжээний танилцуулгыг сурагчдад өгч ажиллав.



1.6 Төв нь үндсэн зорилт чиг үүргээ хэрэгжүүлэх асуудлаар өөрийн орны болон гадаад улс орнуудын төрийн болон төрийн бус байгууллага, иргэнтэй хууль тогтоомжийн хүрээнд харилцан хамтарч ажиллана

-Дэлхийн зөн олон улсын байгууллагатай хамтран сургалт зохион байгуулж, сургалтад хамрагдсан сурагчдын бүтээлээр үзэсгэлэн гаргав.

"ҮНДЭСНИЙ БИЧИГ ҮСГИЙН БАЯР"-ыг тохиолдуулан Горькийн нэрэмжит 01 дүгээр номын сантай хамтран Нийслэлийн ерөнхий боловсролын 103 дугаар сургууль, Нийслэлийн ерөнхий боловсролын 05 дугаар сургуулийн сурагчдад Монголын Хүүхдийн Урлан Бүтээх төвийн Монгол уран бичлэгийн ангийн багш Г.Болормаа, Д.Дуламсүрэн нар Монгол уран бичлэгийн тухай ойлголт, дадлага сургалтыг хүргэв.



Горькийн нэрэмжит 01 дүгээр номын сантай хамтран "Дэлхийн номын баяр"-ын өдрийг тэмдэглэн өнгөрүүллээ. Тус арга хэмжээнд урилгаар Тува СССР Мөнгөн тайга яруу найргийн наадмын түрүү шагналт МЗЭ-ийн гишүүн зохиолч Х.Алтанцэцэг хүрэлцэн ирлээ.



Арт аялал арга хэмжээний хүрээнд Хүүхдийн Урлан бүтээх төв, Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газартай хамтран Өсвөрийн парламентын манлайлагч сурагчдыг тус арга хэмжээнд хамруулан Уран зураг, Монгол Уран бичлэгийн нэг өдрийн сургалтыг явуулав.

Монгол улсын соёлын Яам, "МОНГОЛЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН ДУНД СУРГУУЛИУДЫН БАГШ НАРЫН ХОЛБОО"-ны дэргэдэх HUGO and COLOR клубын уламжлалт Хүүхдийн гар зургийн улсын XV нээлттэй олимпиад амжилттай зохион байгууллаа. Энэ удаагийн олимпиадад 160 гаруй сургуулийн төлөөлөл Уран зураг, Чимэглэх урлаг, Хувцас загварын төрөлд оролцсоноос орон нутгаас 300 орчим, Улаанбаатар хотоос 4700 сурагч, мөн багш нарын ур чадварын уралдаанд 120 гаруй багш нар оролцов.



Монгол улсын Соёлын Яам, Монголын Урчуудын Эвлэл хамтран зохион байгуулдаг Дүрслэх урлагийн хамгийн том наадам болох “ART FAIR 2024” үзэсгэлэнг 2024.05.05-ны өдөр Хүүхдийн Урлан Бүтээх төв хамтран зохион байгууллаа. Чингис хаан Үндэсний музей, МУЭ-ийн Арт галерей, МУЭ-ийн хуучнаар Монументаль чимэглэлийн үйлдвэр байсан Пассаж төв, МУЭ-ийн Уран бүтээлчдийн Нэгдсэн урлан, Хүүхдийн Урлан Бүтээх төв зэрэг 5 объектын 3000 гаруй м2 талбайд зохион байгуулагдах гэж байна. Тус арга хэмжээний дэглэлтийг хариуцан ажиллав.



2024 оны 09 дүгээр сарын 05-ны өдөр Хүүхдийн Урлан Бүтээх төвийн Орд Арт Галерейд Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам, Монгол Улсын Соёл Урлагийн их сургууль, Хүүхдийн Урлан Бүтээх төв, МГАХИ СУРИКОВА нарын хамтарсан “График болон Уран зураг”-ийн мастер класс арга хэмжээг зохион байгуулав. Тус арга хэмжээнд Оросын урлагийн академийн гишүүн Михаил Горшунов болон В.И. Суриковын нэрэмжит уран зургийн академийн багш Лилия Устюгова нар хүрэлцэн ирэх мастер класс сургалтыг хийж Соёл урлагийн их сургуулийн Дүрслэг урлагийн ангийн 20 оюутан мөн Хүүхдийн Урлан Бүтээх төвийн 22 багш хамрагдав.



Нийслэлийн засаг даргын тамгын газрын урилгаар “Олон улсын сурагч солилцооны хөтөлбөр-2024”-ийн хүрээнд Тайландын Хаант улсын Бангкок, Оросын Холбооны улсын Эрхүү, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Өвөр Монголын Өөртөө

Засах орны Хөх хот, Бүгд Найрамдах Солонгос улсын Намянжү, Япон улсын Мияконожо зэрэг 5 улсаас 60 гаруй сурагчид 2024 оны Монголын Хүүхдийн Урлан Бүтээх төвийн үйл ажиллагаатай танилцав.



Дэлхийн хүүхдийн өдрийг тохиолдуулан “Go blue” өдөрлөгийг 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр НҮБ-ийн Хүүхдийн сан, Айсмарк ХХК, Монголын Хүүхдийн Урлан бүтээх төв хамтран зохион байгуулав. Тус өдөр нь НҮБ-ын Хүүхдийн эрхийн конвенц батлагдсан өдөр бөгөөд 2017 оноос эхлэн Дэлхийн Хүүхдийн Өдөр болгон тэмдэглэж байхаар НҮБ-ын Хүүхдийн Сангаас уриалсны дагуу дэлхийн 130 гаруй орон нэгдсэн.

Тус өдөрлөгийн хүрээнд “Цэнхэр зүрх” сэдэвт гар зургийн уралдааныг Айсмарк ХХК, Хүүхдийн Урлан Бүтээх төв хамтран зохион байгуулж уралдааны хүрээнд нийт 250 гаруй сурагч хүүхдүүдийн уран бүтээл ирснээс шилдэг 10 шалгаруулав.





2024 оны 09 дүгээр сарын 14-ний өдөр Эрдэм их сургуультай хамтран “Монгол-Японы соёлын фестиваль-2024” арга хэмжээг зохион байгуулав.

Тус арга хэмжээнд Япон улсаас 13 уран бүтээлч, артистууд хүрэлцэн ирж Япон улсын уламжлалт ханзны уран бичлэг, Үндэсний дуу, хөгжмийн үзүүлбэр, Косплэй хувцас загварын үзүүлбэр, бүжгийн үзүүлбэр мөн Япон хоолны соёлын талаарх илтгэл, эрүүл зөв, хооллолт, зөв амьдрах ухааны танин мэдэхүйн илтгэлүүдийг мэргэжлийн Япон багш, лекторууд танилцуулав.

Уг фестивальд Эрдэм их сургуулийн оюутнууд, Монголын Хүүхдийн Урлан Бүтээх төвийн нийт 1000 гаруй сурагч, эцэг эх хамрагдав.

Тус арга хэмжээний хүрээнд Монголын Хүүхдийн Урлан Бүтээх төвийн Орд арт галерейд Монгол Япон хоёр улсын найрамдлыг харуулсан хүүхдийн гар зургийн үзэсгэлэн дэглэгдэв.



Нийслэлийн алслагдсан дүүрэг хороодод төвийн салбар дугуйланг ажиллуулах санал хүсэлтийн дагуу 2024 оны 02 сарын 16-ны өдөр тусгай хамгаалах байрт нийт 10 хүүхдэд уран зургийн сургалт, 03 сарын 01-ны өдрөөс эхлэн хуваарийн дагуу Дэлхийн зөн байгууллагын байрт очиж нийт 20 хүүхдэд уран зургийн сургалт явуулснаар 12 удаагийн хичээл орж 40- 65 бүтээл хийсэн. Бага насны сурагчид хамрагдсан, эцэг эхийн оролцоог сайн дэмжин ажиллахаар хамтын үйл ажиллагаа уран зураг, баримлын сургалт амжилттай зохион байгуулсан.



1.7. Суралцагчдын мэдлэг, чадвар төлөвшлийг сургалтын явцад анги дэвших, төгсөхөд нь дүгнэх болон сурлагын амжилтын хяналт, үнэлгээ хийх тусгай аргачлалтай байна.

Хүүхдийн урлан бүтээх төвийн 2024 оны шилдэг 25 сурагчдыг шалгаруулав. Үүнд: Нийслэлийн “Шилдэг сурагч”-1, төвийн “Алтан од” медаль-1, хорин гурван дугуйлангийн сурагчдыг тус тус шагнаж урамшуулав.



1.8. Байгууллагын үйл ажиллагааг сурталчлах зорилгоор багш, суралцагчдын хамтарсан, бие даасан бүтээлийн үзэсгэлэн гаргаж, өөрийн оронд болон гадаад улс оронд зохиогдох уралдаан тэмцээнд тогтмол оролцуулна

Хүүхдийн Урлан Бүтээх Төвийн “ОРД” арт галерейд “УРАН ХАРАНДАА” таталбар зургийн улсын анхдугаар уралдаан болов.

Уралдаанд СУИС-ийн Театрын урлагийн сургуулийн Тайз дэлгэцийн зураачийн ангийн оюутнуудын зурж, бүтээсэн макет, тайз болон дүрийн эскиз, жүжгийн жижиг хэрэглэл, уралдааны хоёр ангиллын шилдэг оролцогчдын таталбар зургуудаас бүрдсэн үзэсгэлэн дэглэж олон нийтэд толилуулснаас гадна “Таталбар зураг”, “Жүжгийн дүрийг хэрхэн зурах”, “План зураг”, “Театрын зураачийн онцлог” сэдвээр нээлттэй хичээл зохион байгуулав. Уралдаанд оюутны ангилалд 7 сургуулийн 45 оюутан, Ерөнхий Боловсролын Сургуулийн ангилалд 12 сургуулийн 55 сурагч оролцов.



Хүүхдийн Урлан Бүтээх Төвийн “Эко урлалын” багш Б.Нарантунгалаг 2024 оны 03 дугаар сарын 24-ний өдөр “Орд арт” галерейд “Нам гүм дунд” бие даасан үзэсгэлэн гаргав. Уран бүтээлч нь үзэсгэлэнгээрээ олсон утас болон кофег ашиглан байгальд ээлтэй уран бүтээлийг хийж, өсвөр үеийнхний авьяас чадвар, бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх, урын санг баяжуулах, хэрхэн хөдөлмөрч байхыг харуулсан байв. Энэхүү үзэсгэлэнд нийт 60 гаруй бүтээл дэлгэгдэв.



Монголын шог зураачдын "Шогч бийр" холбооноос Олон улсын инээдмийн баярын өдөрт зориулсан ШОГ зургийн үзэсгэлэнд 9 шог зураачийн 103 бүтээл тавигдаж8 Хүүхдийн урлан бүтээх төв хамтран ажиллалаа.



“Өнгөөр дүрслэн эгшиглэхүй” хичээлээс гадуурх хүүхэд хөгжүүлэх хичээлийн зургийн тайлан үзэсгэлэнг 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдөр Хүүхдийн урлан бүтээх төвийн “Орд” арт галерейд дэглэгдэн толилуулав.

Дүрслэх урлагийн дугуйланд хичээллэдэг 1-ээс 5 дугаар ангийн сурагчдын Уран зургийн бүтээл, Монгол уран зургийн бүтээл, чимэглэх урлал, хар зураг, урам баримал, усан будгийн бүтээлүүд дэглэгдэв. Тус үзэсгэлэнд нийт 300 гаруй бүтээл үзэсгэлэнд тавигдав.



Их эзэн Чингис хааны мэндэлсэн өдөр “Монгол бахархлын өдөр”-ийг тохиолдуулан Ерөнхийлөгчийн ивээл дор жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “Мөнх тэнгэрийн бичиг-2024” Монгол уран бичлэгийн олон улсын үзэсгэлэн 2024 оны 11 дүгээр сарын 02-ны өдөр Монголын Хүүхдийн Урлан Бүтээх төвийн Орд арт галерейд зохион байгуулагдав.

Тус арга хэмжээнд Өвөр Монголын Өөртөө засах орон, Оросын Холбооны улсын Халимаг, Буриад, Эрхүү, Санктпетербург, Франц улс зэргээс 20 гаруй бүтээл, Нийслэл Улаанбаатар хотоос 150 гаруй бүтээл, Орон нутгаас 60 гаруй бүтээл нийт 230 гаруй бүтээл дэглэгдэв. Уран бүтээлч, багш, оюутан болон сурагчдын гэсэн 5 төрөлд тус бүр тэргүүн байр, дэд байр, гутгаар байр тусгай байранд нийт 25 хүн шагнагдав. Шагналыг Ерөнхийлөгчийн боловсрол шинжлэх ухаан, технологийн бодлогын зөвлөх Ч.Лодойравсал, Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Батжаргал, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Соёл урлагийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Сэргэлэн, Боловсролын ерөнхий газрын дарга Т.Ням-Очир, Монголын Хүүхдийн Урлан Бүтээх төвийн захирал Д.Уранбилэг нар гардуулав.



Хүн төрөлхтний ирээдүй болсон хүүхэд, залуучуудад энх тайвны ач холбогдлыг таниулан эх дэлхийгээ хайрлан хамгаалах, хүнлэг энэрэнгүй үзлийг төлөвшүүлэх зорилго бүхий "ЭНХТАЙВАНТАЙ НӨХӨРЛӨӨ" олон улсын гар зургийн уралдаан 2024 оны 10 дугаар сарын 17-ний өдөр Хүүхдийн Урлан Бүтээх Төвийн ОРД АРТ галерейд амжилттай зохион байгуулав.



Нийслэлийн Засаг Даргын Тамгын газар, Нийслэлийн Соёл Урлагийн газар, Нийслэлийн Боловсролын газраас зохион байгуулж байгаа Хүүхэд, өсвөр үеийнхэнд зориулсан "Ирээдүйн хотын иргэн" төслийн хүрээнд Нийслэлийн Ерөнхий боловсролын 74 дүгээр сургуулийн 80 гаруй сурагч 2024 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр Хүүхдийн Урлан Бүтээх төвийн үйл ажиллагаатай танилцан нэг өдрийн дадлага хичээлд хамрагдав.

Тус үйл ажиллагаанд Уран зургийн анхан шатны ангийн багш Д.Энхбаяр, Б.Нарангэрэл нар уран зургийн Мастер класс үзүүлбэр, Хувцас загварын ангийн багш Д.Баярцэцэг хувцасны хялбарчилсан эсгүүр хийх аргачлал дадлага ажил, Уран хатгамлын багш С.Ганцэцэг, Эко гар урлалын багш Б.Нарантунгалаг, Галерейн эрхлэгч Г.Очгэрэл нар байгууллагын үйл ажиллагаа танилцуулах, дүрслэх урлагийн талаарх мэдлэг ойлголтыг олгох танилцуулга лекц хичээлийг орон Монгол уран зургийн багш Н.Мөнхтуул "art cube" арга хэмжээний танилцуулгыг сурагчдад өгч ажиллав.



Хүүхдийн Урлан Бүтээх Төвийн багш нарын уламжлал болгон зохион байгуулдаг шилдэг бүтээлийн “ART & CRAFT-2024” уран бүтээлийн 13 дахь удаагийн үзэсгэлэн 2024 оны 02 дугаар сарын 08-ны өдөр “ОРД” арт галерейд зохион байгуулав.

Үзэсгэлэнгийн шүүгчээр МУБИС-ийн захирал доктор дэд профессор С.Батцоож, “Чингис хаан” музейн үзүүлэн дэглэлт хариуцсан захирал Н.Хосбаяр, Хүүхдийн Урлан Бүтээх Төвийн захирал Д.Уранбилэг нар ажиллаж шилдэг бүтээлүүдийг шалгаруулав.

- Уран зургийн төрөлд: Уран зургийн анхан шатны багш Б.Нарангэрэл “Тусгалд оршихуй” бүтээл
- Гар урлалын төрөлд: Хүүхэлдэй бэлэг дурсгалын багш С.Оюунсайхан “The world of worms” бүтээл
- Чимэглэх урлалын төрөлд: Уран баримлын багш Т.Даваасамбуу “Дөл” бүтээл тус тус шалгарав.

Багш нарын урласан 50 гаруй бүтээлийг хүлээн авч хаягжуулан, ажлын хэсгийн хамт үзэсгэлэнг дэглэн ажиллав.



ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН БОДЛОГЫН ХҮРЭЭНД:

1. Дугуйлангийн сурагчдыг угах үдэх үйлчилгээг багш эцэг, эхийн оролцоотойгоор гүйцэтгэх хяналт тавин ажиллав.
2. Гараас гарт үйлчилгээнд хяналтыг тавьж ажиллав.
3. 2024 оны 02 дугаар сарын 23-ны өдөр Баянзүрх дүүргийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын хэлтсийн даргатай хүүхдийн хөгжил, оролцооны ажлын хүрээнд хамтран ажиллах талаар уулзалтыг хийв.
4. 2024 оны 03 дугаар сарын 4-ний өдөр Чингэлтэй дүүргийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын хэлтсийн хүүхдийн хөгжил, хамгааллын албаны ахлах хүүхдийн хөгжил, оролцооны ажлын хүрээнд хамтран ажиллах талаар уулзалтыг хийв.
5. Г.Болормаа багштай Монгол уран бичлэгийн хулсан үзгийн ангийн сурагч Батцэцэг, Энхтуяа нарийн хамтарсан “Монгол бичиг бидний бахархал” сэдэвт бие даасан үзэсгэлэнг 2024 оны 03 дугаар сарын 01-ний өдөр Нийслэлийн ерөнхий боловсролын 53 дугаар сургуулийн урлаг заалд Монгол уран бичлэгийн хулсан үзгийн ангийн Г.Болормаа багш, Орчин үеийн уран зургийн ангийн Д.Энхбаяр багш, Галерейн эрхлэгч Г.Очгэрэл, Мэдээлэл технологийн ажилтан Б.Даваадоржийн хамтаар дэлгэж, хүүхдийн хөгжил оролцооны үйл ажиллагааны хүрээнд Баянзүрх дүүргийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын хэлтэстэй хамтран ажиллав.
6. Г.Болормаа багштай Монгол уран бичлэгийн хулсан үзгийн ангийн сурагч Батцэцэг, Энхтуяа нарийн хамтарсан “Монгол бичиг бидний бахархал” сэдэвт бие даасан үзэсгэлэнг 2024 оны 03 дугаар сарын 06-ны өдөр Нийслэлийн

ерөнхий боловсролын 24 дүгээр сургуулийн урлаг заалд Монгол уран бичлэгийн хулсан үзгийн ангийн Г.Болормаа багш, Орчин үеийн уран зургийн ангийн Д.Энхбаяр багш, Галерейн эрхлэгч Г.Очгэрэл, Мэдээлэл технологийн ажилтан Б.Даваадоржийн хамтаар дэлгэж, хүүхдийн хөгжил оролцооны үйл ажиллагааны хүрээнд Чингэлтэй дүүргийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын хэлтэстэй хамтран ажиллав.

7. 2024 оны 10 дугаар сарын 22-ны өдөр жижүүр 3.Одгэрэлийн Хүүхдийн урлан бүтээх төвийн нийтийн эзэмшлийн талбайд хамгаалах хэрэгсэлгүй тэжээвэр амьтан сурагч хүүхдийн эд хөрөнгөд халдсан мэдээллийн дагуу Сүхбаатар дүүргийн цагдаагийн 01 дүгээр хэлтэст шуурхай мэдээллийг хүргэж тус иргэн хууль сануулах үйлчилгээ үзүүлэн байгууллагын үйл ажиллагааны журам Хүүхэд хамгааллын тухай хуулийн хэрэгжилтийн талаар сануулах арга хэмжээ авч ажиллав.
8. Нийслэлийн Засаг Даргын Тамгын газар, Нийслэлийн Соёл Урлагийн газар, Нийслэлийн Боловсролын газраас зохион байгуулж байгаа Хүүхэд, өсвөр үеийнхэнд зориулсан "Ирээдүйн хотын иргэн" төслийн хүрээнд Нийслэлийн Ерөнхий боловсролын 74 дүгээр сургуулийн 80 гаруй сурагч 2024 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр Хүүхдийн Урлан Бүтээх төвийн үйл ажиллагаатай танилцан нэг өдрийн дадлага хичээлд хамрагдав.

Тус үйл ажиллагаанд Уран зургийн анхан шатны ангийн багш Д.Энхбаяр, Б.Нарангэрэл нар уран зургийн Мастер класс үзүүлбэр, Хувцас загварын ангийн багш Д.Баярцэцэг хувцасны хялбарчилсан эсгүүр хийх аргачлал дадлага ажил, Уран хатгамлын багш С.Ганцэцэг, Эко гар урлалын багш Б.Нарантунгалаг, Галерейн эрхлэгч Г.Очгэрэл нар байгууллагын үйл ажиллагаа танилцуулах, дүрслэх урлагийн талаарх мэдлэг ойлголтыг олгох танилцуулга лекц хичээлийг орон Монгол уран зургийн багш Н.Мөнхтуул “art cube” арга хэмжээний танилцуулгыг сурагчдад өгч ажиллав.



ХОЁР. ХУУЛИАР ОЛГОСОН НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:

2.1 Төсөв, санхүүгийн чиглэлээр

2024 оны жилийн төсвийн гүйцэтгэл зөрчилгүй, өглөг авлагагүй ажиллаж байна. Хуулиар тогтоосон хугацаанд <https://shilendans.gov.mn/org/4315> сайтад мэдээллийг тогтмол байршуулж мөн <http://huuhdiinurlan.ub.go.v.mn/> сайт, “Монголын Хүүхдийн Урлан Бүтээх төв” Фэйсбүүк пейж болон мэдээллийн самбарт тогтмол мэдээллүүдийг шинэчлэн байршуулж, үйл ажиллагааны ил тод байдлыг ханган ажиллав.

Батлагдсан төсвийн хүрээнд гурвалсан гэрээний үүргээр болон заалны түрээсийн орлогоор төсөвт орлого төвлөрүүлэх чиглэлээр байгууллагын төрийн сангийн дансанд түрээсийн 5.400.000₮ орлогыг Гурвалсан гэрээгээр, байгууллага хооронд 3.600.000₮ төвлөрүүлэв.

Хүүхдийн урлан бүтээх төв нь 2024 онд батлагдсан төсвийн хуваарийн дагуу орон нутгийн төсвөөс 1,788,439,600,00 төгрөгийн санхүүжилт авч өөрийн орлого төлөвлөгөө 12,300,00,00 төгрөг төвлөрүүлэхээс 15,132,925 төгрөг төвлөрүүлсэн. Нийт 1,803,572,525.00 төгрөгөөс 1,524,981,396,00 зарцуулалт хийгдэж 278,591,129.00 төгрөгийг үлдэгдлийг төрийн сан банканд төвлөрүүлэн ажилласан.

2024 оны 02 дугаар сарын 08-ны өдөр Хүүхдийн Урлан Бүтээх төвийн өмч хамгаалах зөвлөлийн 2024 онд хийгдэх ажлын төлөвлөгөөг боловсруулан батлуулж 2024 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн төвийн захирлын А/13 тоот тушаалын дагуу 2024 оны 01 дүгээр сарын 05-ны өдөр төвийн үндсэн хөрөнгөөс актлагдах эд хогшлын талаар хэлэлцэв. Комиссын хурлаар 19 нэр төрлийн 4.296.486,32 төгрөгийн (Дөрвөн сая хоёр зуун ерэн зургаан мянга дөрвөн зуун наян зургаа) тавилга эд хөрөнгө, 6 нэр төрлийн 2.438.652,00 төгрөгийн (Хоёр сая дөрвөн зуун гучин найман мянга зургаан зуун тавин хоёр) машин тоног төхөөрөмж нийт 25 нэр төрлийн 6.735.138,32 төгрөгийн (Зургаан сая долоон зуун гучин таван мянга нэг зуун гучин найм) үндсэн хөрөнгийг актлах санал оруулав.

2024 онд Хүүхдийн Урлан Бүтээх төв нь Монгол улсын хууль тогтоомжид заасны дагуу холбогдох хууль, журмыг баримтлан тендер зарлан худалдан авах ажиллагаа хийсэн. Үүний хүрээнд 2024 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр Хүүхдийн Урлан Бүтээх төвийн захирлын А/03 тоот тушаалын дагуу төвд шаардлагатай тоног, төхөөрөмж худалдан авах гэрээг “Хасу энерги интернэшил” компанитай байгуулж барааг хүлээн авах, хүлээлцэх ажлын хэсгийг байгуулж ажилласан. Төвийн захирлын А/03 тоот тушаалын дагуу байгуулагдсан ажлын хэсэг болон “Хасу энерги интернэшил” компани 2024 оны 06 дугаар сарын 60-ны өдөр барааг хүлээлцэх ажлыг гүйцэтгэв. Тус худалдан авах ажиллагааны хүрээнд 25 нэр төрлийн 139.370.000 (Нэг зуун гучин есөн сая гурван зуун далан мянган) төгрөгийн тоног төхөөрөмжийг хүлээж авав.





2024 оны 06 дугаар сарын 15-ны өдөр Хүүхдийн Урлан Бүтээх төвийн Өмч хамгаалах байнгын зөвлөл хуралдан хавсралтад заасан хөрөнгийг акталж данс бүртгэлээс хасах тухай тушаалын дагуу өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор зохих журмын дагуу устгалын ажлыг зохион байгуулж данснаас хасах талаар хэлэлцэв. Хүүхдийн урлан бүтээх төвийн захирлын 2024 оны 01 дүгээр сарын 04-ний А/13 тоот тушаал, Нийслэлийн өмчийн харилцааны газрын даргын 2024 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн А/102 тоот тушаалын дагуу Өмч хамгаалах байнгын зөвлөл 2024 оны 06 дугаар сарын 13-ны өдөр Хүүхдийн урлан бүтээх төвийн Тавилга, эд хогшлын дансанд бүртгэлтэй 12 нэр төрлийн 4.284.362,14 (Дөрвөн сая хоёр зуун наян дөрвөн мянга гурван зуун жаран хоёр төгрөг арван дөрөв мөнгө), машин тоног төхөөрөмжийн төгрөгийн 5 нэр төрлийн 1.967.636 (Нэг сая есөн зуун жаран долоон мянга зургаан зуун гучин зургаа төгрөг) нийт 17 нэр төрлийн 6.251.998,14 (Зургаан сая хоёр зуун тавин нэгэн мянга есөн зуун ерэн найман мянган төгрөг арван дөрөв мөнгө) бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж сэлбэг болгон ашиглах, мөн хогийн машинд ачуулах зэргээр устгалд оруулж ажиллав.



Хүүхдийн Урлан Бүтээх төвийн захирлын 2024 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн А/10 тоот тушаалын дагуу Төвийн Өмч хамгаалах байнгын зөвлөл 2024 оны 12 дугаар сарын 19-ний өдрөөс 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн хооронд төвийн үндсэн хөрөнгө, хангамжийн материалыг тоолох жилийн эцсийн тооллогын ажлыг зохион байгуулав. Тус ажлын хэсгийн даргаар Нийгмийн ажилтан Б.Ариунбат, ажлын хэсгийн гишүүдэд Нярав Д.Оюунчимэг, Лаборант С.Чимгээ, Галерейн эрхлэгч Г.Очгэрэл, Слесарь Ц.Даваадорж нар оролцов.

2024 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн Нийслэлийн Засаг Даргын Тамгын газраас Хүүхдийн Урлан Бүтээх төвд тоног төхөөрөмж хүлээлгэн өгөх актын дагуу Canon IR C3326I загварын 12.709.180 (Арван хоёр сая долоон зуун есөн мянга нэг зуун наяд) төгрөгийн үнэ бүхий хэвлэгчээс 2 ширхэг буюу нийт 25.418.360 (Хорин таван сая дөрвөн зуун арван найман мянга гурван зуун жар) төгрөгийн тоног төхөөрөмжийг үнэ төлбөргүй хүлээн авч байгууллагын хөрөнгөд бүртгэн авч Хүний нөөцийн ажилтан Н.Отгонтуяа, Архив, бичиг хэргийн ажилтан Б.Мөнхтуул нарт картжуулсан.

2.2 Хяналт-шинжилгээ, үнэлгээний чиглэлээр

Төвийн нийт 21 багшийн 2023-2024 оны хичээлийн эхний хагас жилийн журнал хөтлөлтөд Дотоод хяналт, хуулийн зөвлөх Б.Лхамноржин, Нийгмийн ажилтан Б.Ариунбат нар 2024 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр дотоод хяналт, шалгалтыг хийж ажиллав.

Байгууллагын багш албан хаагчдын ажлын гүйцэтгэлд хяналт үнэлгээг 4 удаа хийж ажиллав.

2.3 Архив, албан хэрэг, хөтлөлтийн чиглэлээр

Албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаа нэгдсэн удирдлагаар хангаж, “UB.ERP” системийн Edoc, Өргөдөл гомдол, Тайлан судалгаа, дэд системүүдийн ашиглалтыг бүрэн хангаж ажиллахад албан хэрэг хөтлөлтийн www.edoc.ulaanbaatar.mn цахим хуудсыг тогтмол ашиглаж, хариутай албан бичгийг хугацаанд нь шийдвэрлэж ажиллав.

Архивын үйл ажиллагааг хууль, дүрэм, зааврын дагуу хөтлөн явуулахад төвийн Захирлын А, Б тушаалуудыг нөхөн бүрдүүлэлтээр цахим хэлбэрт оруулж, байгууллагын архивын ажлыг заавар, журмын дагуу зохион байгуулан ажиллав.

2024 оны байдлаар :

№	Албан бичиг	Нийт тоо	Үүнээс	Шийдвэрлэлт
1	Ирсэн бичиг	151	52 хариутай 99 хариугүй	100%
2	Явсан бичиг	111	111 хариугүй	100%
3	Өргөдөл	31		100%

2.4 Ил тод байдлын чиглэлээр

Хүүхдийн урлан бүтээх төвийн үйл ажиллагааг иргэдэд ил тод, нээлттэй байлгах хүрээнд <http://huuhdiinurlan.ub.go.v.mn/> сайт, “Монголын Хүүхдийн Урлан Бүтээх төв” Фэйсбүүк хуудсыг идэвхтэй байлгаж, байгууллагын мэдээллийн самбарын мэдээллүүдийг тогтмол шинэчлэн байршуулж ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлтийг хангаж ажиллав.



2.5 Хүний нөөцийн чиглэлээр

Төрийн албан хаагчийг мэргэшүүлэх сургалтын төлөвлөгөөг боловсруулж биелэлтийг хангаж ажиллах, албан хаагчдын сургалт, ажиллах нөхцөл нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2024 оны төлөвлөгөөг 4 зорилтын хүрээнд 11 ажил үйлчилгээ төлөвлөж биелэлтийг ханган ажиллав.

Хөтөлбөрийн хүрээнд Нийслэлийн Засаг даргын Тамгын газар болон харьяа хэлтэс албадаас зохион байгуулсан “Үр дүнд суурилсан төлөвлөлт, гүйцэтгэл”, Нийслэлийн Нутгийн захиргааны байгууллагын “Хүний нөөцийн асуудал хариуцсан

албан хаагчдын HR 2024 чуулган", "Бүсүүдийн хөгжлийн үндэсний чуулган", Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын удирдах албан тушаалтнууд, албан хаагчдад зориулсан "Авлигын эсрэг сургалт, арга хэмжээ", "Монгол улсын нийслэл хүрээ" эрдэм шинжилгээний хурал, "Монголын Залуучуудын холбооны анхдугаар чуулга уулзалт" зэрэгт албан хаагчдыг хамруулж ажиллав.

№	Хамрагдсан сургалт	Сургалтанд хамрагдсан ажилчдын нэрс	Албан тушаал
1	"Үр дүнд суурилсан төлөвлөлт, гүйцэтгэл"	Н.Отгонтуяа	Хүний нөөцийн мэргэжилтэн
		Л.Атар	Сургалтын менежер
2	"Хүний нөөцийн асуудал хариуцсан албан хаагчдын HR 2024 чуулган"	Н.Отгонтуяа	Хүний нөөцийн мэргэжилтэн
		Л.Атар	Сургалтын менежер
3	"Бүсүүдийн хөгжлийн үндэсний чуулган"	Д.Уранбилэг	Захирал
		Н.Отгонтуяа	Хүний нөөцийн мэргэжилтэн
4	БНСУ-д зохион байгуулагдах "Global HR forum 2024" форум	Л.Атар	Сургалтын менежер
5	"Авлигын эсрэг сургалт, арга хэмжээ"	Д.Уранбилэг	Захирал
		Н.Отгонтуяа	Хүний нөөцийн мэргэжилтэн
		Х.Отгонбаяр	Нягтлан бодогч
6	"Монгол улсын нийслэл хүрээ" эрдэм шинжилгээний хурал	Б.Ариунбат	Нийгмийн ажилтан
		Г.Очгэрэл	Галерейн эрхлэгч
7	"Монголын Залуучуудын холбооны анхдугаар чуулга уулзалт"	Б.Ариунбат	Нийгмийн ажилтан
		Д.Дуламсүрэн	Монгол уран бичгийн багш
8	"Бодлогын баримт бичиг боловсруулах арга зүйн сургалт"	Г.Очгэрэл	Галерейн эрхлэгч
9	Гамшгаас хамгаалах сургалт арга зүйн төвийн сургалт	Хамт олноороо	

Төрийн албан хаагчийн нийгмийн баталгааг хангах төлөвлөгөөг боловсруулж биелэлтийг хангаж ажиллахад төвийн албан хаагчдын ажиллах нөхцөл боломжийг хангах чиглэлээр байгууллагаас олгох зохих тэтгэмж, урамшууллыг хууль тогтоомжийн хүрээнд тухай бүр шийдвэрлэн ажиллаа. Албан хаагчдын үйл ажиллагааны үнэлгээ, ажилласан жил, ур чадварыг харгалзан ажлын үр дүнд үндэслэн зохих нэмэгдлүүдийг хоол унааны зардлын хамт тогтмол олгож байна.

Төвийн албан хаагчдаас улсад болон төрийн байгууллагад олон жил үр бүтээлтэй, хамт олноо манлайлж ажиллаж байгаа шилдэг, тэргүүний ахмад багш, албан хаагч нийт Засгийн газар, Нийслэлийн Засаг даргын шагналд тодорхойлж шагнаж урамшуулсан.

Үүнд: Анхан шатны уран зургийн дугуйлангийн багш Б.Нарангэрэл, Монгол зургийн дугуйлангийн багш Н.Мөнхтуул, Анхан шатны уран баримлын дугуйлангийн багш Б.Ичинхорлоо нарыг Монгол Улсын Соёлын тэргүүний ажилтан, Дотоод хяналт, хуулийн зөвлөх Б.Лхамноржинг Хууль зүйн яамны жуух бичиг, Үйлчлэгч Б.Цолмонжаргалыг Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны "Хүндэт жуух

бичиг”, мөн нийслэл Улаанбаатар хот үүсгэн байгуулагдсаны 385 жилийн ойн хүрээнд төвийн 20 албан хаагчдыг “Нийслэлийн ойн медаль”-иар шагнаж урамшуулав.

НЭМЭЛТ АЖЛЫН ХҮРЭЭНД:

Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн баталсан 2024 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн “Нийслэлийн нутаг дэвсгэрт бүх нийтийн их цэвэрлэгээний ажлыг зохион байгуулах тухай” А/05 дугаар тушаал, 2024 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн бүх нийтийн их цэвэрлэгээ зохион байгуулах тухай албан бичгийн дагуу сар шинийн баярыг угтсан бүх нийтийн их цэвэрлэгээ зохион байгуулах тухай арга хэмжээг зохион байгуулж Хүүхдийн Урлан Бүтээх Төвийн нийт 47 албан хаагчид 2024 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн 11 цагт байгууллагын эргэн тойрон, гудамж, нийтийн эзэмшлийн талбайн хог хаягдал, цас мөсийг цэвэрлэн их цэвэрлэгээ хийж ажиллав.

Нийт 47 албан хаагч байгууллагын ойр орчмын 50 метр зай талбайд цэвэрлэгээ хийн гадна талбайн 5 хогийн сав, ил хаягдсан хог хаягдлыг цэвэрлэв.



Монгол Улсын Биеийн тамир спортын тухай хуулийн 8 дугаар зүйл, Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд Хүүхдийн Урлан Бүтээх төвийн нийт албан хаагчдыг биеийн тамир, спортын арга хэмжээнд татан оролцуулах, тэдний бие бялдрыг чийрэгжүүлэх, хөдөлгөөний хомсдолоос урьдчилан сэргийлэх, амралт чөлөөл цагийг зөв зохистой өнгөрүүлэхэд чиглэсэн байгууллагын албан хаагчдын дунд гар бөмбөгийн аварга шалгаруулах тэмцээнийг 2024 оны 03 дугаар сарын 15-ны өдөр зохион байгуулж ажиллав.



2024 оны 04 дүгээр сарын 22-ны өдөр Нийслэлийн засаг даргын тамгын газрын А заалд 2024 оны Олон Улсын Хүүхдийн Эрхийг хамгаалах өдрийг тэмдэглэн

өнгөрүүлэх тухай ажлын хэсгийн хуралд оролцов.



2024 оны 05 дугаар сарын 15-ны өдөр Монголын Залуучуудын холбооны анхдугаар чуулга уулзалтад Төрийн ордонд Монгол уран бичлэгийн анхан шатны багш Д.Дуламсүрэн, Нийгмийн ажилтан Б.Ариунбат нар оролцов.

2024 оны 05 дугаар сарын 02-ны өдөр NOVOTEL зочид буудлын хурлын танхимд Нийслэлийн Засаг даргын тамгын газраас зохион байгуулагдсан Монгол улсын нийслэл хүрээ эрдэм шинжилгээний хуралд Галерейн эрхлэгч Г.Очгэрэл, Нийгмийн ажилтан Б.Ариунбат нар оролцов.

Нийслэлийн Нутгийн захиргааны байгууллагын “Хүний нөөцийн асуудал хариуцсан албан хаагчдын HR 2024 чуулган”-д Хүний нөөцийн мэргэжилтэн Н.Отгонтуяа, Сургалтын менежер Л.Атарын хамт хамрагдав.

“Бүсүүдийн хөгжлийн үндэсний чуулган”-д 10 дугаар сарын 26-ны өдөр Улаанбаатар хотноо зохион байгуулагдаж, захирал Д.Уранбилэг, Хүний нөөцийн мэргэжилтэн Н.Отгонтуяагийн хамт хамрагдав. Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр болон “Хурдтай хөгжлийн төлөөх зориг” хамтарсан Засгийн газрын гэрээнд “БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН БОДЛОГО”-ыг хэрэгжүүлэхээр тусгагдсан.

Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Удирдлагын академи хамтран Монгол улсын хөгжлийн бодлого, төлөвлөлт, байгууллагын стратеги болон гүйцэтгэлийн төлөвлөгөөг уялдуулан төлөвлөх, тэдгээрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх арга зүйн талаар мэдлэг олгох “Үр дүнд суурилсан төлөвлөлт, гүйцэтгэл” сэдэвт танхим болон цахим хосолсон сертификаттай сургалтад Хүний нөөцийн менежер Н.Отгонтуяа, Сургалтын менежер Л.Атар нар хамрагдав.

Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын удирдах албан тушаалтнууд, албан хаагчдад зориулсан “Авлигын эсрэг сургалт, арга хэмжээ”-нд Захирал Д.Уранбилэг, Хүний нөөцийн мэргэжилтэн Н.Отгонтуяа, Нягтлан бодогч Х.Отгонбаярын хамт сургалтанд хамрагдав.

“Төсөвт байгууллагуудын нягтлан бодогч нарын сургалтын хөтөлбөр” сургалтанд Нягтлан бодогч Х.Отгонбаяр хамрагдав.

“Хөгжлийн бодлогын баримт бичгийн төлөвлөлт, тайлагналт, хяналт шинжилгээ үнэлэгээ” сургалтанд Дотоод хяналт, хуулийн зөвлөх Б.Лхамноржин 2 удаа хамрагдав.

Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4.5 дахь заалт, нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2020 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн Энгийн хог хаягдал цэвэрлэх, ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах журам 32/03 дугаар тогтоолын дагуу 2024 онд нийт 12 удаагийн цэвэрлэгээг зохион байгуулж байгууллагын эргэн тойрон, гудамж, нийтийн эзэмшлийн талбайн хог хаягдал, цас мөсийг цэвэрлэн их цэвэрлэгээ хийж ажиллав. Нийт 48 албан хаагч байгууллагын ойр орчмын 50 метр зай талбайд цэвэрлэгээ хийн гадна талбайн 5 хогийн сав, ил хаягдсан хог хаягдлыг цэвэрлэж ажиллав.



2024 оны 09 дүгээр сарын 21-ний өдөр Нийслэлийн Засаг Даргын 2024 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн А/1048 дугаар захирамжийн дагуу “Автомашингүй өдөр-2024” арга хэмжээнд Хүүхдийн Урлан Бүтээх төв Нийслэлийн төв талбайд байгууллага сурталчлан, суралцагч хүүхдүүдийн уран бүтээлээр үзэсгэлэн гаргаж, “FACE ART” зохион байгуулж ажиллав.

Тус арга хэмжээгээр байгууллагын 16 багш 4 ээлжээр гарч байгууллага сурталчлах, 2024-2025 оны нэмэлт элсэлтийн бүртгэлийг хөтлөн, 3 багш “FACE ART” хийж, Нийгмийн ажилтан Б.Ариунбат тус арга хэмжээг зохион байгуулан Дотоод хяналт, хуулийн зөвлөх Б.Лхамноржин хяналт тавьж ажиллав.





Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 58 дугаар зарлигийг хэрэгжүүлэх зорилготой Засгийн газрын 2021 оны 350 дугаар тогтоолын хүрээнд “Тэрбум мод” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиглэлийн дагуу 2024 оны 10 дугаар сарын 05-ны өдөр Хүүхдийн Урлан Бүтээх төвийн нийт албан хаагчид Хан-Уул дүүргийн 14 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах заагдсан талбайд байрлах мод, ногоон байгууламжийг услах, сэргээх ажлыг зохион байгуулав.



Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлан хэрэгжүүлж буй “Эрүүл Монгол Хүн” үндэсний хөдөлгөөнийг үндэслэн Монголын Хүүхдийн Урлан Бүтээх төвийн нийт албан хаагчдын дунд “Эко хоолны өдөрлөг-2024”-ийг 2024 оны 10 дугаар сарын 25-ны өдөр зохион байгуулав.

Тус өдөрлөгийн хүрээнд нийт албан хаагчдыг 6 багт хувааж баг тус бүр өөр өөрсдийн сонгосон өнгийн дагуу түүний онцлог шинж чанарт нийцүүлсэн эрүүл хоол, хүнсийг бэлтгэн өрсөлдөв.





Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлан хэрэгжүүлж буй “Эрүүл Монгол Хүн” үндэсний хөдөлгөөн, Биеийн тамир, спортын тухай хууль, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд идэвхтэй хөдөлгөөн, эрүүл амьдралын хэвшил бүхий иргэн, гэр бүлийг дэмжих, биеийн тамир, спортоор хичээллэх ач холбогдлыг ойлгуулах мэдлэг, мэдээлэл олгох, төр, төрийн бус байгууллагын хамтын ажиллагааг нэмэгдүүлэх, спортод ээлтэй орчин бүрдүүлэх зорилготой биеийн тамирын арга хэмжээг улсын хэмжээн зохион байгуулсантай холбогдуулан Монгол Хүүхдийн Урлан Бүтээх Төвийн нийт ажилтан, албан хаагчдын дунд 2024 оны 11 дүгээр сарын 08-ны өдрөөс 11 дүгээр сарын 22-ны өдрийн хооронд 6 багийн 4 төрлийн / гар бөмбөг, ажлын байрны дасгал, дартс, ширээний теннис / спортын өдөрлөгийг амжилттай зохион байгуулж ажиллав.

Уг спорт өдөрлөгийн хүрээнд:

- 2024 оны 11 дүгээр сарын 01-ний өдөр нийт албан хаагчдыг 6 багт хуваарилан, арга хэмжээний удирдамжийг боловсруулав.
- 2024 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр нийт албан хаагчдын дунд гар бөмбөгийн тэмцээнийг явуулав.
- 2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр 6 багийн ширээний теннис, дартсын тэмцээнийг Хүүхдийн Урлан Бүтээх Төвийн “Орд арт галлерей”-д зохион байгуулав.
- 2024 оны 11 дүгээр сарын 22-ны 6 багийн дунд ажлын байрны дасгалын тэмцээнийг зохион байгуулав.

Хүүхдийн Урлан Бүтээх төвийн 2024 оны спорт өдөрлөгийн тэргүүн байр “Хар” баг, дэд байр “Улаан” баг, гутгаар байр “Ногоон” баг тус тус шалгарч, ажлын байрны дасгал төрөлд тэргүүн байр “Солонгор” баг, дэд байр “Шар” баг, гутгаар байр “Ногоон” баг тус тус шалгарч тус арга хэмжээ амжилттай зохион байгуулагдав.

Үр дүн:

Албан хаагчдын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, идэвхтэй хөдөлгөөн, эрүүл амьдралын хэвшил бий болгох, хамт олны эвсэг уур амьсгал бүрдүүлсэн.



"Жендэрт суурилсан хүчирхийллийн эсрэг 16 хоногийн аян"-ыг "ОХИД ЭМЭГТЭЙЧҮҮД ХААНА Ч АЮУЛГҮЙ-ШАЛТАГ БҮҮ ТООЧ" уриатайгаар 2024 оны 11 дүгээр сарын 25-аас 12 дугаар сарын 10-ны өдрүүдэд зохион байгуулж байгаатай холбогдуулан Хүүхдийн урлан бүтээх төв 2 удаагийн мэдээ мэдээлэл, постыг бэлтгэн байгууллагын цахим хаягаар нийт 10.487 иргэнд хүргэж ажиллав.



2024 оны 08 дугаар сарын 26-ны өдөр Нийслэлийн Онцгой байдлын газрын дэргэдэх, Гамшгаас хамгаалах сургалт арга зүйн төвтэй хамтран Хүүхдийн Урлан Бүтээх төвийн нийт албан хаагчдыг гамшиг, онцгой байдлын үед авах анхан шатны арга хэмжээ болон байгууллага дээрх хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах талаарх мэдлэг ойлголт өгөх сургалтад хамрагдаж ажиллав. Тус арга хэмжээнд Монголын Хүүхдийн Урлан Бүтээх төвийн нийт 46 албан хаагч хамрагдав.



Нийслэлийн Засаг Даргын Тамгын газар, Хүний нөөцийн хөгжлийн төвөөс зохион байгуулсан бодлогын баримт бичиг боловсруулах арга зүйн сургалтад 2024 оны 02 дугаар сарын 06, 03 дугаар сарын 6-ны өдрүүдэд хамрагдав.



2024 оны 06 дугаар сарын 01-ний өдөр Олон Улсын Хүүхдийн Эрхийг хамгаалах өдрийг тэмдэглэн өнгөрүүлж байгаатай холбогдуулан Хүүхдийн Урлан

Бүтээх төв Нийслэл Улаанбаатар хотын төв талбайн нэгдсэн арга хэмжээ болон Төв Цэнгэлдэх хүрээлэнд зохион байгуулагдсан KIDS ART FESTIVAL-д оролцон дүрслэх урлагийн талаар олон гайхалтай мэдлэг, мэдээллийг хүүхэд багачуудад сурталчлан таниулан оролцов.



Сүрлэн урлалын дугуйлангийн сургалтын хэрэглэгдэхүүн болох сургалтад ашиглах гол хэрэглэгдэхүүн сүрлийг Дархан урлалын Хонгор сумын тариан талбайгаас бэлтгэж ажиллав.



ДУГНЭЛТ


Хүүхдийн урлан бүтээх төв нь 2024 онд "ӨВ СОЁЛОО ДЭЭДЭЛДЭГ БҮТЭЭЛЧ МОНГОЛ ХҮҮХДИЙН ТӨЛӨӨ" эрхэм зорилгоо хэрэгжүүлэн хүүхэд багачуудын хэрэгцээ хүсэл сонирхолд нийцүүлэн 18 төрлийн 23 дугуйланд нийт 2100 хүүхдийг дүрслэх урлаг, гар урлал, техник технологийн чиглэлээр үнэ төлбөргүй сурган хөгжүүлж байна.

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, байгууллагын дүрмээр хүлээсэн чиг үүргийг бүрэн хэрэгжүүлж, үйл ажиллагааны ил тод байдлыг ханган ажиллаж байна.

Байгууллагын батлагдсан төсвийг зүй зохистой зарцуулан, төсвийн хэмнэлт гаргаж өр төлбөргүй ажиллалаа.

ХЯНАСАН:
ЗАХИРАЛ  Д.УРАНБИЛЭГ

ҮХЗӨЛГЭ БИЛЭГ

ТАЙЛАН ГАРГАСАН:
ХҮНИЙ НӨӨЦИЙН МЭРГЭЖИЛТЭН  Н.ОТГОНТУЯА